



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/06

Хархорин сум

Бүх тендерээс татгалзах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2025 оны А/06 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАХХСЗДТГ/20250202001/01/01 урилгын дугаартай Засаг даргын Тамгын газарт тээвэр, шатахуун нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт шаардлагад нийцсэн тендер ирээгүй тул бүх тендерээс татгалзсугай.

2.Тендер шалгаруулалтыг хуулийн дагуу дахин зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Н.Нямдаваа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТ-ЭРДЭНЭ